

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/149/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2022 он	Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр Утас: 70378845 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: Г.Батмягмар Утас: 70373089 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.БАТЦЭНГЭЛ ТАНАА

2022.02.25 № 134
танай -ны № -т
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/Ш.МӨНХБАЯР/



009020182

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	379,088,486.37	645,447,035.38
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,786,523,646.66	2,701,043,985.75
	Нийт хөрөнгийн дүн	<u>3,165,612,133.03</u>	<u>3,346,491,021.13</u>
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,165,612,133.03	3,346,491,021.13
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>3,165,612,133.03</u>	<u>3,346,491,021.13</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	4,373,070,818.27	11,212,525,187.90
	Үйл ажиллагааны зардлын дүн	4,310,515,964.59	10,054,286,084.92
	Үйл ажиллагааны үр дүн	62,554,853.68	1,158,239,102.98
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	951,127,214.88
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>62,554,853.68</u>	<u>207,111,888.10</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
	Тайлант оны үр дүн	62,554,853.68	207,111,888.10
	Эцсийн үлдэгдэл	3,165,612,133.03	3,346,491,021.13
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,350,091,858.16	3,679,665,911.03
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,332,987,168.16	3,665,137,511.03
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>17,104,690.00</u>	<u>14,528,400.00</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	<u>(17,104,690.00)</u>	<u>(14,528,400.00)</u>
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,311,417,900.00	2,283,894,816.82
	Урсгал зардал	2,311,417,900.00	2,283,894,816.82
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,311,417,900.00	2,283,894,816.82
	Улсын төсвөөс санхүүжих	2,293,909,600.00	2,262,133,460.82
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	17,508,300.00	21,761,356.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Эрүүл мэндийн газрын удирдлага, хүний нөөцийн ур чадвар, манлайллыг дээшлүүлж, чанарын менежментийн тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлэн, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, зохион байгуулах үйлчилгээг олон улсын жишгээр хөгжүүлнэ” гэсэн зорилтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлжээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 6 дугаар зүйлд заасантай нийцээгүй гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 266,236.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 184,954.8 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, зөрчил арилгуулах 1 албан шаардлага хүргүүлж, 81,282.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Орлого үр дүнгийн тайлангийн өмнөх оны үр дүн, өмчийн өөрчлөлтийн тайлан өмнөх оны тайлант үеийн үр дүн 125,900.0 мянган төгрөгөөр зөрүүтэй. Өмчийн өөрчлөлтийн тайлан дахь өмнөх оны хуримтлагдсан үр дүн эхний үлдэгдэл 59,054.8 мянган төгрөгийн зөрүүтэйг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй байна.

4.3 Албан шаардлага

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт, мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан ажилтны цалингийн сүлжээг эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээгээр олгож байгаа зөрчлийг арилгах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт 6.1-т ТҮ-7 “Маркетинг, олон нийттэй харилцах ажилтан, **хүний нөөцийн ажилтан**” гэж заасантай нийцэхгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд Харуул, хамгаалалтын ажлын тендер шалгаруулалтад харьцуулалтын аргыг хэрэглэсэн боловч нэг ч оролцогч ирээгүйгээс шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т заасантай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Тендер сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалтыг мөрдөж ажиллах.

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 163 мэдээллээс хугацаандаа оруулсан 154 мэдээлэл, хугацаа болоогүй 4 мэдээлэл, хугацаа хоцроосон 5 мэдээлэл байна. Мөн 5 сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээ 57,282.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасантай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Цалин, хөлсний нэмэгдлийг тооцохдоо анхан шатны баримтыг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(сая төгрөгөөр)

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	4	266.2	1	184.9	-	-	1	-	2	81.3
2	Төсөл, хөтөлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	ЗГТС	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	4	266.2	1	184.9	-	-	1	-	2	81.3